



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2025/009-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2025 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер: М.Нарантуяа

Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Миндүг аудит ХХК-ийн

Аудитор: Б.Бүзмаа

Утас: 91160110 Цахим хаяг: buzmaa@mindug.mn

Гүйцэтгэх захирал: С.Энхтөр

Утас: 95957791 Цахим хаяг: director@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
3.1 Төлбөрийн акт.....	10
3.4 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.02.25 № 217

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаахан шарга театрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага өөрийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй. 2024 онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,382.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 310.1 сая төгрөг нийт 2,692.1 сая төгрөгийн төсөв батлагдсан. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 104.9 сая төгрөг, улс болон орон нутгийн төсвөөс нийт 2,692.1 сая төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоор 105.9 сая төгрөг нийт 2,798.0 сая төгрөг төвлөрүүлсэнээс, 2,742.7 сая төгрөг урсгал зардал, 55.3 сая төгрөг хөрөнгө оруулалтын зардалд зарцуулсан 104.9 сая төгрөг төсөвт төвлөрүүлсэнийг тайланд толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Жаахан шарга театр өөрийн үйл ажиллагааны орлого 105.9 сая төгрөг төвлөрүүлсэн боловч уг орлогыг олохтой холбоотой зардал болон ажилчдын урамшуулалд 45.2 сая

төгрөгийг илүү зарцуулсан нь үр дүнгийн тайланд тусгагдсанаас өөрөөр санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Бусад асуудал

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театр үйл ажиллагааны тайлант хугацаанд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласан 3 ажилтанд нийт 23.7 сая төгрөгийн тэтгэмж, өндөр настны тэтгэвэрт гарч буй 4 ажилтанд 82.6 сая төгрөг, ахмад ажилтнуудад 8.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн зардлын гүйлгээ гарсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red rectangular official stamp of the State Audit Agency of Mongolia is placed over a handwritten signature. The stamp contains the Mongolian text 'МОНГОЛЫН АУДИТЫН АГЫН ГЭР' (State Audit Agency of Mongolia) and 'УЛСЫН АУДИТ' (State Audit). The signature is written in black ink over the stamp.

Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	408,252,821.20	329,254,791.03
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	104,993,550.39	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	104,993,550.39	-
3121	Төгрөг	104,993,550.39	-
31211	Төрийн сангийн харилцах	104,993,550.39	-
35	БАРАА МАТЕРИАЛ	303,259,270.81	329,254,791.03
351	Түүхий эд материал	113,685,258.40	112,675,435.40
35110	Тусгай зориулалттай материал	113,685,258.40	112,675,435.40
354	Хангамжийн материал	189,574,012.41	216,579,355.63
35410	Бичиг хэргийн материал	248,000.00	248,000.00
35420	Аж ахуйн материал	37,922,246.00	40,159,121.50
35430	Сэлбэг хэрэгсэл	48,000.00	588,000.00
35470	Бусад хангамжийн материал	151,355,766.41	175,584,234.13
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,447,301,862.73	2,481,090,611.09
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,447,301,862.73	2,481,090,611.09
392	Биет хөрөнгө	2,386,455,779.46	2,420,743,277.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,554,787,648.00	2,554,787,648.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	- 310,285,263.76	- 375,354,528.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	73,300,000.00	58,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	- 42,644,444.58	- 34,594,444.62
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	242,344,544.00	351,970,419.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	- 164,071,578.45	- 189,815,037.02
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,160,134.00	89,706,581.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	- 20,135,259.75	- 33,957,359.75
393	Биет бус хөрөнгө	60,846,083.27	60,347,333.24
39301	Програм хангамж	2,745,000.00	2,745,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	- 1,802,916.73	- 2,301,666.76
39303	Бусад биет бус хөрөнгө	59,904,000.00	59,904,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,855,554,683.93	2,810,345,402.12
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,855,554,683.93	2,810,345,402.12
51	Засгийн газрын хувь оролцоо	2,855,554,683.93	2,810,345,402.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	910,260,365.77	910,260,365.77
51101	Өмч: - төрийн	906,369,876.63	906,369,876.63
512	Хуримтлагдсан үр дүн	- 67,022,214.73	- 112,231,496.54
51210	Өмнөх үеийн үр дүн	- 67,022,214.73	- 67,022,214.73
51220	Тайлант үеийн үр дүн	-	- 45,209,281.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,012,316,532.89	2,012,316,532.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,855,554,683.93	2,810,345,402.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,246,598,187.33	2,892,673,085.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,829,550.00	200,638,175.00
120	Нийтлэг татварын бус орлого	46,829,550.00	200,638,175.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,829,550.00	105,866,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,829,550.00	105,866,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		86,264,175.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		8,508,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,199,768,637.33	2,692,034,910.57
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,892,734,937.33	2,381,964,510.57
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,892,734,937.33	2,381,964,510.57
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	307,033,700.00	310,070,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	307,033,700.00	310,070,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,212,814,337.40	2,937,882,367.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,212,814,337.40	2,937,882,367.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,941,379,535.40	2,707,662,044.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,283,320,449.56	1,889,885,884.00
210101	Үндсэн цалин	976,789,675.01	1,209,165,267.26
210102	Нэмэгдэл	177,026,215.72	470,527,091.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,126,148.30	67,297,050.66
210104	Урамшуулал	84,378,410.53	142,896,474.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	159,097,915.03	233,727,316.00
210201	Тэтгэврийн даатгал	110,088,162.52	160,450,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,982,532.16	16,600,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,024,292.56	9,484,516.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,399,487.98	9,438,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,603,439.81	37,753,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	302,033,700.00	305,070,400.00
210301	Гэрэл, цахилгаан	9,574,850.00	9,976,273.35
210302	Түлш, халаалт	285,533,680.00	287,669,404.89
210303	Цэвэр, бохир ус	6,925,170.00	7,424,721.76
2104	Хангамж, бараа материалын зардал	17,341,249.00	35,790,861.20
210401	Бичиг хэрэг	3,664,275.00	6,171,400.00
210402	Тээвэр, шатахуун	6,990,400.00	21,341,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,469,376.00	1,004,581.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,217,198.00	7,272,990.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,603,638.33	31,543,753.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,931,403.00	720,478.00
210604	Урсгал засвар	28,672,235.33	30,823,275.00
2107	Томилолт, зочны зардал	4,100,000.00	47,695,400.00
210702	Дотоод албан томилолт	4,100,000.00	47,695,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,639,650.54	46,570,190.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,048,450.54	44,217,590.72
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,411,200.00	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	1,352,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	115,242,932.94	117,378,239.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,509,640.00	6,202,166.03
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	107,733,292.94	111,176,073.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	271,434,802.00	230,220,322.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	271,434,802.00	125,223,350.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	9,927,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	72,247,600.00	82,625,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	189,028,304.00	23,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,158,898.00	8,970,450.00

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	104,996,972.73
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	104,996,972.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	33,783,849.93	- 45,209,281.81
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	33,783,849.93	- 45,209,281.81

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,246,598,187.33	2,797,900,910.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,829,550.00	105,866,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	46,829,550.00	105,866,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,829,550.00	105,866,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,829,550.00	105,866,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,199,768,637.33	2,692,034,910.57
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,892,734,937.33	2,381,964,510.57
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,892,734,937.33	2,381,964,510.57
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	307,033,700.00	310,070,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	307,033,700.00	310,070,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,122,443,233.92	2,847,623,760.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,122,443,233.92	2,847,623,760.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,851,008,431.92	2,617,403,438.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,281,696,091.70	1,889,885,884.00
210101	Үндсэн цалин	924,845,981.67	1,209,165,267.26
210102	Нэмэгдэл	213,094,551.20	470,527,091.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,377,148.30	67,297,050.66
210104	Урамшуулал	84,378,410.53	142,896,474.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	160,362,848.89	233,727,316.00
210201	Тэтгэврийн даатгал	110,088,162.52	160,450,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,982,532.16	16,600,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,289,226.42	9,484,516.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,399,487.98	9,438,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,603,439.81	37,753,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	302,033,700.00	305,070,400.00
210301	Гэрэл, цахилгаан	9,574,850.00	9,976,273.35
210302	Түлш, халаалт	285,533,680.00	286,214,032.94
210303	Цэвэр, бохир ус	6,925,170.00	8,880,093.71
2104	Хангамж, бараа материалын зардал	14,575,000.00	35,790,421.00
210401	Бичиг хэрэг	2,889,124.00	6,171,859.80
210402	Тээвэр, шатахуун	6,990,400.00	21,341,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,469,376.00	1,004,581.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,226,100.00	7,272,090.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,089,335.33	23,602,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,959,299.33	1,859,050.00
210602	Тавилга	-	359,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	-
210604	Урсгал засвар	19,630,036.00	21,384,200.00
2107	Томиллолт, зочны зардал	4,100,000.00	47,695,400.00
210702	Дотоод албан томиллолт	4,100,000.00	47,695,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,401,470.00	75,194,911.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,310,270.00	72,774,911.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,411,200.00	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,680,000.00	1,420,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,749,986.00	6,436,856.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,749,986.00	6,436,856.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	271,434,802.00	230,220,322.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	271,434,802.00	125,223,350.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	9,927,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	72,247,600.00	82,625,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	189,028,304.00	23,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,158,898.00	8,970,450.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	104,996,972.73
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	104,996,972.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	124,154,953.41	- 49,722,850.39
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	21,175,000.00	55,270,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,175,000.00	55,270,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,175,000.00	55,270,700.00
223001	Бусад хөрөнгө	21,175,000.00	55,270,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	- 21,175,000.00	- 55,270,700.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	102,979,953.41	- 104,993,550.39
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		104,993,550.39
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	104,993,550.39	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	906,369,876.63	2,016,526,782.03	- 124,355,824.66	2,798,540,834.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	906,369,876.63	2,016,526,782.03	- 124,355,824.66	2,798,540,834.00
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	57,013,849.93	57,013,849.93
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	906,369,876.63	2,016,526,782.03	- 67,341,974.73	2,855,554,683.93
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	906,369,876.63	2,016,526,782.03	- 67,341,974.73	2,855,554,683.93
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	906,369,876.63	2,016,526,782.03	- 67,341,974.73	2,855,554,683.93
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	- 45,209,281.81	- 45,209,281.81
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	906,369,876.63	2,016,526,782.03	- 112,551,256.54	2,810,345,402.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,692,034,400.00	2,902,894,460.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,692,034,400.00	2,847,623,760.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,575,981,500.00	2,617,403,438.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,889,885,484.00	1,889,885,884.00
210101	Үндсэн цалин	1,179,480,000.00	1,209,165,267.26
210102	Нэмэгдэл	479,071,600.00	470,527,091.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76,692,000.00	67,297,050.66
210104	Урамшуулал	154,641,884.00	142,896,474.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	233,727,316.00	233,727,316.00
210201	Тэтгэврийн даатгал	160,450,800.00	160,450,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	16,646,816.00	16,600,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,438,300.00	9,484,516.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,438,300.00	9,438,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	37,753,100.00	37,753,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	305,070,400.00	305,070,400.00
210301	Гэрэл, цахилгаан	11,000,000.00	9,976,273.35
210302	Түлш, халаалт	285,533,700.00	286,214,032.94
210303	Цэвэр, бохир ус	8,536,700.00	8,880,093.71
2104	Хангамж, бараа материалын зардал	22,500,000.00	35,790,421.00
210401	Бичиг хэрэг	7,200,000.00	6,171,859.80
210402	Тээвэр, шатахуун	7,200,000.00	21,341,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	1,004,581.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,200,000.00	7,272,090.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,023,300.00	23,602,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,023,300.00	1,859,050.00
210602	Тавилга	-	359,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	21,384,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,700,000.00	47,695,400.00
210702	Дотоод албан томилолт	2,700,000.00	47,695,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,275,000.00	75,194,911.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,855,000.00	72,774,911.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,420,000.00	1,420,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,800,000.00	6,436,856.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,800,000.00	6,436,856.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116,052,900.00	230,220,322.73
2135	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	104,996,972.73
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	104,996,972.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	116,052,900.00	125,223,350.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,927,500.00	9,927,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	82,425,400.00	82,625,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23,700,000.00	23,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	8,970,450.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	55,270,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	55,270,700.00
223001	Бусад хөрөнгө	-	55,270,700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	2,797,900,910.57
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	2,381,964,510.57
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	2,381,964,510.57
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	310,070,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	310,070,400.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	105,866,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	105,866,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,013,596.98	104,993,550.39
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	104,993,550.39	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7.2 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил¹ илэрснээс, 1.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн, 1.5 сая төгрөгийн алдааг залруулсан. Илрүүлсэн 5.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт

Жаахан шарга театрын 1 албан хаагчид 1,471.0 мянган төгрөгийн цалингийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл илүү бодож олгосон нь төсөвт төлөвлөгдөөгүй зарцуулалт хийгдсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн 41.2.2 (батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах гэж заасны дагуу төсөвт тусган батлуулж төсвийн хүрээнд зардал болгон гаргаагүй), 41-р зүйлийн 41.2.3-т (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах гэж заасны дагуу ажилчдад олгох зардлыг зохих дансанд гүйцэтгэлээр тусгаж тайлагнана) гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт

Байгууллагын даргын Б/43 тоот тушаалаар 77 албан хаагчид шинэ жилийн бэлгийн 4,300.5 мянган төгрөг олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлтийн 16.5.5 (батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах), 41 дүгээр зүйлийн 41.2.2 (батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах), 41.2 дахь хэсгийн 41.2.3 (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1 (Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно), 12.1.4 (хуулиар зөвшөөрөөгүй бусад), дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

3.3 Зөвлөмж

1. Илрүүлэлт

Үндсэн хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн байна. Энэ нь УСНББОУС 17. (Үйлчилгээ үзүүлэхэд ашиглах хөрөнгийг үндсэн хөрөнгөөр бүртгэнэ), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3. (жинхэнэ хэрэгжилтийн), 5.1.4. (үнэн зөв байх), Төсвийн тухай хуулийн 6.3.2. (санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах), заалтуудыг мөрдөж ажиллах заалтуудыг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Үндсэн хөрөнгийн бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн хөтөлж, бараа материалын дансанд бүртгэсэн хөрөнгийг үндсэн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хөрөнгийн ангилалд шилжүүлж залруулах, цаашид санхүүгийн бүртгэл, тайлагналын үнэн зөв байдлыг хангах хяналтын тогтолцоог сайжруулан хэрэгжүүлэх

2. Илрүүлэлт

Шилэн дансны мэдээллийн 171 төрөлд хамаарах мэдээнээс 4 мэдээг хугацаанд нь байршуулаагүй нь мэдээллийн бүрдүүлэлт, хяналт хангалтгүй байсантай холбоотой байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.(тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх) заалтыг мөрдөж ажиллаагүй нь зүйд нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж

Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол, шуурхай байршуулж, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангах дотоод хяналтын тогтолцоог сайжруулан, хариуцсан албан хаагчдын хяналт, хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

3. Илрүүлэлт

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 21 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 (Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2 (Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна), үүнд 6.2.1 (Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон), “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцоолоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалтыг мөрдөж, Орон нутгийн өмчийн албанд асуудлыг шийдвэрлүүлэхээр хүргүүлэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн	1	1,500.0			1	1,500.0	1	1,500.0				
Дүн	1	1,500.0			1	1,500.0	1	1,500.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цалингийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг давхардуулан олгосон	1	1,471.0	1	1,471.0				
Шинэ жилийн бэлгийн мөнгө олгосон	1	4,300.5			1	4,300.5		
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 21 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна	1						1	
Дүн	3	5,771.5	1	1,471.0	1	4,300.5	1	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
4 мэдээг хугацаанд нь байршуулаагүй	1		1			
Дүн	1		1			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн	1		1			